



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2016 оны 01 сарын 14 өдөр

Дугаар 12

Улаанбаатар хот


Сургалтад оролцуулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар, “Улаанбаатар төмөр зам” хувь нийлүүлсэн нийгэмлэгийн хооронд хамтран ажиллах тухай санамж бичгийн 2.1.1-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас бүх шатны төсвийн үр ашигтай, хариуцлагатай байдлыг хангах зорилгоор төсвийн хэмнэлтийн горимд шилжүүлэн ажиллаж, санхүүгийн нөхцөл байдал хүндрэлтэй байгаатай холбогдуулан “Галт тэрэгний хөдөлгөөний зохицуулалтын нэгдсэн төв” Улсын төсөвт үйлдвэрийн газар нь дотоод нөөц бололцоогоо дайчлан галт тэрэгний хөдөлгөөний нэгдсэн төв байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахыг тус төвийн захирал Т.Ариунбаатарт даалгасугай.

2. Техник-эдийн засгийн үндэслэл боловсруулахтай холбогдуулан 2016 оны 1 дүгээр сарын 23-наас 2016 оны 2 дугаар сарын 01 хүртэл хугацаанд ОХУ-ын Эрхүү хотноо зохион байгуулагдах сургалтанд 15 албан хаагчийн Улаанбаатар-Эрхүү, Эрхүү-Улаанбаатарын чиглэлд ирж, очих замын зардал (суудлын вагон гаргаж аялуулах), хөтөлбөрийн дагуу сургалтын зардалд шаардагдах 20 653 528 (хорин сая зургаан зуун тавин гурван мянга таван зуун хорин найм) төгрөгийг зохих журмын дагуу санхүүжүүлэхийг Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэг /Л.Пүрэвбаатар/-т үүрэг болгосугай.

3. Сургалтанд хамрагдах бүрэлдэхүүнийг бодлогын удирдамж, удирдлага зохион байгуулалт, зааварчилгаагаар хангаж ажиллахыг Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Б.Артур/-т, “Галт тэрэгний хөдөлгөөн зохицуулалтын нэгдсэн төв” байгуулах техник-эдийн засгийн үндэслэл боловсруулалтад хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Б.Жаргал/-т үүрэг болгосугай.

САЙД  М.ЗОРИГТ